



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/112

Шивээговь сум

“Нүүдэлчин Монгол-2023” соёлын биет бус өвийн их наадмын арга хэмжээнд оролцоход хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Нүүдэлчин Монгол-2023” соёлын биет бус өвийн их наадмын арга хэмжээнд оролцоход 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Тус соёлын биет бус өвийн их наадамд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3.Наадамд зарцуулагдах 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал), нярав (Б.Баярцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ч.СУГАРМАА

21
Сумын Засаг даргын ...3... оны 08-р сарын ...6...-ны өдрийн А/№ дугаар захирамжийн хавсралт



“Нүүдэлчин Монгол-2023” соёлын биет бус өвийн
их наадмын төсөв

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хонь	ш	1	280,000	280,000
2	Хулдаас /шалны/	метр	12	22,500	270,000
Нийт					550,000